

Хязгаарт багтсан санал**1. Урсгал зардал**

сая төгрөг

ТЕЗ, Агентлаг, байгууллага		2024 Гүйц	2025 Төсөв (тод)	2026 Хязгаар	2026 ТЕЗ САНАЛ
ТЕЗ					
Байгууллага	Санхүүгийн зохицуулах хороо	11,692,049	20,677,057	19,937,382	19,937,382
Дэд зориулалт	80101 Үндсэн үйл ажиллагаа	9,264,684	16,193,367	15,548,767	15,465,374
Дэд зориулалт	82324 Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх	1,262,975	3,194,919	3,207,749	3,291,142
Дэд зориулалт	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	66,751	15,786	15,786	15,786
Дэд зориулалт	80224 Зөвлөл, хороодын гишүүдийн цалин	100,567	-	-	-
Дэд зориулалт	80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	409,311	447,683	447,683	447,683
Дэд зориулалт	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	70,020	112,636	2,830	2,830
Дэд зориулалт	80226 Байр ашиглалтын зардал	517,742	712,666	714,567	714,567

2. Хөрөнгө оруулалт

№	ТЕЗ	Үргэлжлэх	Шинэ
		-	-

3. Зээл, тусламж

№	ТЕЗ	Зээл, тусламж
		-

Хязгаарт багтаагүй санал

1. Урсгал зардал

/сая төгрөг/					
ТЕЗ	Арга хэмжээ	Тайлбар ¹	2026 Хязгаар	2026 ТЕЗ Санал	Нэмэгдүүлэх санал
Санхүүгийн зохицуулах хороо	80101 Үндсэн үйл ажиллагаа	Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу төрийн албан хаагчдын албан тушаалын цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, цол, зэрэг дэв, хоол, унааны хөнгөлөлт, бусад нэмэгдэл хөлс, үр дүнгийн урамшуулал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал; Хорооны үндсэн үйл ажиллагаатай холбоотой эх үүсвэр дутагдаж байгаа эрх зүйн орчныг бүрдүүлэх, хуулиудын шинэчилсэн найруулга, төслүүдийг боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах, шинээр гарсан хууль тогтоомжийг сурталчилан таниулах, зохицуулалттай зах зээлийн эрсдэлийг үнэлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын томилолтын зардал, бичиг хэрэг, тээвэр шатахуун, ном, хэвлэлийн зардал, шуудан холбоо, интернэтийн төлбөр, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл болон урсгал засвар болон бараа үйлчилгээний бусад зардал;	15,548,767	20,366,504	4,817,737
	82324 Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх	1. Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас улс орнуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, үр дүнтэй байдлыг үнэлэх шинэчилсэн 5-р шатны аргачлалыг 2024 онд баталсан. Энэхүү нарийвчилсан аргачлалыг ашиглан улс орнууд өөрсдийн хууль, дүрэм журмыг үр дүнтэй хэрэгжүүлж, ашиглаж байгаа эсэхийг хянана. Иймд МУТСТ урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх хүрээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлж, шинэ технологитой холбоотой эрсдэлийг бууруулах оновчтой бодлого боловсруулах зэргээр дараагийн шатны Харилцан үнэлгээний бэлтгэл ажлыг ханган ажиллах шаардлагатай; 2. Санхүүгийн зохицуулах хорооноос бэлтгэгдсэн олон улсын үнэлгээ хийх эрхтэй 2-3 үнэлгээчнийг Ази, номхон далайн бүлгийн хамтарсан үнэлгээчний багт ажиллуулж, бусад улсын Харилцан үнэлгээ, явцын үнэлгээ хийлгэх, Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн хүрээнд саарал, хар жагсаалтад орсон улсын явцын үнэлгээг хийж, ажиллах зардал. 3. Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2025.02.28-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/79 дүгээр тушаалаар Монгол Улсын дараагийн шатны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалаар 2025 онд хийх ажлын хэсгийг байгуулж, ажиллаж байна. Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд тус Хорооны зохицуулалттай 8 салбарын үндэсний хэмжээний аюул занал болон эмзэг байдлын үр дүн гарах бөгөөд салбар тус бүрийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ, зөвлөмжийг тус үнэлгээнд тусгана. Энэ хүрээнд салбарын оролцогчдод үр дүнг танилцуулж, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулж, соён гэгээрүүлэх, хэвлэл мэдээллийн зардал гаргах зайлшгүй шаардлагатай тул 2026 оны төсөвт тусгасан. 4. Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр бүс нутгийн ач холбогдол бүхий олон улсын хурал, чуулганыг Монгол Улсад зохион байгуулах тул холбогдох зардлыг 2026 оны төсөвт тусгасан. 5. Монгол Улсын 2026 оны Явцын тайланг боловсруулж Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-т хүргүүлж, тус бүлгийн жил тутмын чуулга уулзалтад оролцон, тайлангаа хамгаалж, батлуулах зардал.	3,207,749	6,062,937	2,855,188

Санхүүгийн зохицуулах хороо	82324 Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх	<p>6.Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас хийгдэх, дараагийн шатны харилцан үнэлгээнд бэлтгэх ажлын хүрээнд, шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн дагуу: мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлын үнэлгээг хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/75 дугаар тушаалаар байгуулсан. Энэхүү ажлын хэсгээс Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог цогцоор үнэлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.</p> <p>7.Хорооны зохицуулалтын хамрах хүрээ өргөжиж, зохицуулалтын байгууллагуудын бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл өсөн нэмэгдэж байна. Үүнтэй холбогдон эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг боловсонгүй болгох, эрсдэлийг үнэлэх аргачлал, тоон болон чанарын өгөгдөл цуглуулах маягт, шалгуур үзүүлэлтийг зах зээлийн өсөлт, олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай тулгарч байна. Иймээс мэдээлэх үүрэгтэй этгээд болон хянан шалгагчдын гар ажиллагааг багасгаж, хяналт шалгалтыг бодит цагийн горимоор тасралтгүй хэрэгжүүлэх хүрээнд эрсдэлийн үнэлгээний программ хангамжийг нэвтрүүлнэ.</p> <p>8.Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2023.01.09-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг биелүүлэхээр хорооноос баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний төлөвлөгөө (2023-2030)”-нд тусгасан ажлуудыг 2026 онд зохион байгуулна.</p>			
	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд цаг үеийн мэдээ, мэдээллийг нийтэд мэдээлэх, түгээхэд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг олон нийтэд сурталчлан түгээх: Даатгалын багц хууль, Банк бус санхүүгийн тухай хууль, Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль, Амьдралын даатгалын журам (ипотекийн урт хугацааны даатгал шилжилт) г.м СЗХ, ЦЕГ-ын хамтарсан 2025 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан “Цахим орчинд үйлдэгдэж байгаа санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ”-г зохион байгуулах Иргэдэд санхүүгийн боловсрол олгох, санхүүгийн боловсролыг сайжруулах ажлын хүрээнд санхүүгийн залилан, луйвраас урьдчилан сэргийлэх талаар мэдээ, видео контентыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран бүтээх зардал;	15,786	187,681	171,895
	80224 Зөвлөл Хороо, комиссын гишүүдийн цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар Улсын Их Хурлын 2025.01.16-ны өдрийн 04, 05 дугаар тогтоолоор Хорооны дарга, гишүүдийг томилсон. Хорооны орон тооны бус 4 гишүүн, Хяналтын зөвлөлийн орон тооны бус 1 дарга, 4 гишүүдийн цалин хөл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал;	-	270,000	270,000
	80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	Олон гишүүн байгууллагын төлбөр хураамжийн гадаад валютын ханшийн зөрүү	447,683	622,994	175,312
	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, тэтгэвэр	Төрийн албаны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам, Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөр, хүний нөөцийн бодлогын баримт бичигт заасны дагуу нийт албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, буцалтгүй тусламж олгох, сургаж хөгжүүлэх ажлыг тасралтгүй хэрэгжүүлэх, зохион байгуулах тэтгэмжийн зардал; Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын дагуу өндөр насны тэтгэвэрт гарах 2 хүний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох зардал;	2,830	605,154	602,324

Санхүүгийн зохицуулах хороо	80226 Байр ашиглалтын зардал	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газартай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу төлөх ус, дулаан, цахилгаан, бараа бүтээгдэхүүн, ажиллах хүчний цалин хөлс, байр ашиглалтын зардал нэмэгдсэн	714,567	763,271	48,704
	80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	<p>“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийн 6.1.13-д “иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах.” гэж тусгайлан заасан.</p> <p>Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд тодорхой хөтөлбөр боловсруулж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.</p> <p>Иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэхтэй холбоотой зорилт дэвшүүлсэн нь санхүүгийн зах зээл дэх зөв хэрэглээг бий болгож, банкнаас бусад санхүүгийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, урт хугацаанд Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралын түвшинг сайжруулах, өрхийн санхүүгийн сахилга бат дээшлэх ач холбогдолтой. Технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ хөгжиж, цахим хэрэглээ нэмэгдэж буйтай холбоотой цахим залилан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн залилан, луйвраас урьдчилан сэргийлэх 2. Орон нутгийн иргэдэд болон тэтгэвэрийн насны ахмадууд, гарааны бизнес эрхлэгчдэд, залуу үе оюутан залуус руу чиглэсэн сургалтууд, 3. Тогтвортой, ногоон санхүүжилтийн чиглэлээр 4. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад чиглэсэн хөтөлбөр боловсруулж зайлшгүй зохион байгуулагдах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах 	-	317,500	317,500

2. Хөрөнгө оруулалт²

ТЕЗ	Үргэлжлэх	Шинэ	Тайлбар	2026 ТЕЗ Санал
Санхүүгийн зохицуулах хороо	-	Компьютер, тоног төхөөрөмж, худалдан авах	Цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон, элэгдлээрээ өртгөө нөхсөн компьютер, тоног төхөөрөмжийг хагас болон бүтэн жилийн тооллогын комиссын санал, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн актлах шаардлагатай болсон. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /FATF/-аас өгсөн зөвлөмжийн дагуу цахим хяналт, зохицуулалтын орчныг бүрдүүлж, сервер сүлжээний тоног төхөөрөмжийг орчин үеийн стандартын дагуу шинэчлэх шаардлагатай. УИХ-аас 2022 онд баталсан Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр нэмэгдсэн албан хаагчдад компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авна.	541,181,900
	-	Сургалтын танхим болон албан хэрэгцээнд шаардагдах тавилга, эд хогшил худалдан авах	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.13-т зааснаар “Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах” ажлын хүрээнд санхүүгийн мэдлэг олгох иж бүрэн танхим тохижуулна. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр нэмэгдсэн албан хаагчдад тавилга, эд хогшил худалдан авна.	113,105,000
	-	Зохицуулалттай этгээдийн тайланд эрсдэлийн үнэлгээ хийх программ хийлгэх болон бусад программуудыг төрийн мэдээллийн системүүдтэй холбох шинэчлэл хөгжүүлэлт хийлгэх	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, дата мэдээллийг нэгтгэх, үнэлэх программ хийлгэнэ. Гадаад валютын арилжааны харилцагчийг таньж мэдэх, арилжааны мэдээллийг бодит цагийн горимоор хянах систем хөгжүүлэх, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тайлан мэдээг хүлээн авах цахим системийн хөгжүүлэлтийн зардал /и-баримт, power BI холболт/ тус тус багтсан болно.	734,000,000
	-	Засгийн газрын 4-р байрны /Санхүүгийн зохицуулах хороо/ урсгал засвар хийлгэх	Санхүүгийн зохицуулах хорооны барилга 1961 онд ашиглалтад орсон бөгөөд ашиглалт, насжилтын улмаас урсгал засвар хийх шаардлагатай болсон. Зарим хэсэгтээ мөөгөндөртөж, чийгтэх болсон нь албан хаагчдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй.	284,000,000

²Хязгаарт багтаагүй хөрөнгө оруулалтын жагсаалт

3. Зээл, тусламж³

ТЕЗ	Зээл, тусламж

³Хязгаарт багтаагүй зээл, тусламж

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН САНАЛ

ТЕЗ-ийн нэр: САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

/мян.төг/

А. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН			Б. ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ									
Хүрэх үр дүнгийн дугаар	Хөтөлбөрийн хүрэх үр дүн	№	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт			Зорилтот түвшин			Мэдээллийн эх сурвалж			
			Шалгуур үзүүлэлт	Хэмжих зүйл	Хэмжих нэгж	Он	Түвшин	2026	2027	2028	Мэдээллийн эх сурвалжийн нэр	Мэдээлэл боловсруулагч, хариуцагч байгууллага
1	2	3	4	5	6	8	9	10	11	12	13	
70204	Санхүүгийн зах зээлийн зохицуулалт											
1	Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.	1	Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах журмын төслийн тоо	Зохицуулах харилцаа, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох үйл ажиллагаа	Тоо	2024	30	13			Хорооны үйл ажиллагааны тайлан	Санхүүгийн зохицуулах хороо
2	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хэмжээний хөтөлбөрт суурилсан “Санхүүгийн зохицуулах хорооноос Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023-2030)”-нд тусгагдсан 2026 онд хийх ажлуудыг хэрэгжүүлнэ.	1	“Санхүүгийн зохицуулах хорооноос Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023-2030)”-нд тусгагдсан ажлууд	Хэрэгжилтээр	Тоо	2024	-	Хэрэгжилтээр			Хорооны үйл ажиллагааны тайлан	Санхүүгийн зохицуулах хороо
3	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын техник шаардлага, шууд хэрэгжилтийн стандартын дагуу МУТС эрдэлийн үнэлгээний асуулгыг боловсронгуй болгоно.	1	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Хорооны зохицуулалттай салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс авах МУТС эрдэлийн үнэлгээний асуулгын тоо	Зохицуулалттай мэдээлэх үүрэгтэй этгээд	Тоо	2024	1,200	1,200			Хорооны үйл ажиллагааны тайлан	Санхүүгийн зохицуулах хороо
4	Даатгалын байгууллагууд технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэхийг дэмжих	1	Технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо	Технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ	Тоо	2024	-	5			Хорооны үйл ажиллагааны тайлан	Санхүүгийн зохицуулах хороо
5	Санхүүгийн зах зээлийн судалгаа шинжилгээг сайжруулна.	1	Эрдэм шинжилгээ, судалгааны тоо	Зохицуулах харилцаа, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох үйл ажиллагааны судалгаа	Тоо	2024	18	22			Хорооны үйл ажиллагааны тайлан	Санхүүгийн зохицуулах хороо
6	Зохицуулалтын салбараас оролцогчдод мэргэжлийн эрх олгох сургалт хийх замаар санхүүгийн боловсролыг дээшлүүлнэ.	1	Зохицуулалттай салбараас оролцож байгаа оролцогчидын тоо	Сургалтад оролцогчдын тоо	Тоо	2024	2,312	2,500			Хорооны үйл ажиллагааны тайлан	Санхүүгийн зохицуулах хороо
7	Иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	1	Сургалт болон олон нийтийн арга хэмжээ зохион байгуулсан тоо	Сургалт арга хэмжээнд оролцогчдын тоо	Тоо	2024	-	20,000			Хорооны үйл ажиллагааны тайлан	Санхүүгийн зохицуулах хороо